



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 1/63

Хэрлэн сум

Авлигын эсрэг сургалт зохион
байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах, мөн төрийн байгууллагуудад соён гэгээрүүлэх, байгууллагын дарга нарт авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг бий болгох арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Д.Мягмарбаатар

Хууль эрх зүйн хэлтсийн даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн
бичиг:

Г.Тэмүүжин

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн Нутгийн захиргааны
байгууллагын бодлого тогтоол
шийдвэрийн хэрэгжилт хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд:

М.Шаравгаваа

Хууль эрх зүйн хэлтсийн Хууль
тогтоомжийн мэдээлэл системчлэл
дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Ж.Энхбат

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн Компьютер, мэдээлэл
технологи хариуцсан мэргэжилтэн

Ш.Эрдэнэжаргал

Хүний нөөц, агентлаг хариуцсан
мэргэжилтэн

Б.Энх-Уянга

Нутгийн захиргааны нэгж, Төрийн
үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Б.Хулан

Төсөвт байгууллагын төлбөр тооцоо
хариуцсан мэргэжилтэн

2.

2.Авлигын эсрэг сургалтын ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн (Г.Тэмүүжин)-д, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Мягмарбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА